

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**



**Байгууллагын стандарт**

---

**МАНАЙ ЭРДЭМТЭД ЦУВРАЛ БҮТЭЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ШААРДЛАГА**

**БСТ .....**

Албан хэвлэл

## БАЙГУУЛЛАГЫН СТАНДАРТ

### Ангилалтын код

“Манай эрдэмтэд” цуврал бүтээлд тавигдах ерөнхий шаардлага, формат	

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректорын .... оны ... дүгээр сарын ...-ны өдрийн .... тоот тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

### 1. Хамрах хүрээ

1.1. Энэхүү стандарт нь “Манай эрдэмтэд” цуврал бүтээлд тавигдах ерөнхий шаардлага, форматыг тогтооно.

### 2. Ерөнхий шаардлага

2.1. “Манай эрдэмтэд” бүтээлийн зорилго нь ШУТИС-ийн эрдэмтдийн судалгааны бүтээлийн үр дүнг нийтийн хүртээл болгох юм.

2.2. ШУТИС-ийн албан ёсны энэхүү цуврал бүтээлд тухайн салбарыг хөгжүүлэхэд манлайлан оролцож, үнэтэй хувь нэмэр оруулж, эрдэм шинжилгээний дорвитой бүтээл туурвисан, ШУТИС-д олон жил үр бүтээлтэй ажиллаж буй эрдэмтэд бүтээлээ нийтэлнэ.

### 3. Цуврал бүтээлийн агуулга

3.1. Нэг сэдэвт бүтээл

3.2. Нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн дээж

3.3. Эрдэм шинжилгээ, судалгааны төслийн үр дүн, тойм

3.4. Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлүүдийн товчоон

3.5. Үйлдвэрлэл, практикт нэвтрүүлсэн бүтээл, оюуны өмчөөр баталгаажуулсан бүтээлийн товчоон;

### 4. Цуврал бүтээлд тавигдах шаардлага

4.1. Бичиглэлийн формат:

Хэмжээ	ISO B5
Хуудасны тоо	300-аас ихгүй нүүртэй
Үсгийн фонд	TIMES NEW ROMAN
Эх бичвэрийн үсгийн өндөр /size/	11 pt
Бүлгүүдийн гарчиг	11 pt, том үсгээр
Мөр хоорондын зай /line spacing/	1,15 lines
Хуудасны зүүн талаас авах зай /left margin/	23 мм
Хуудасны баруун талаас авах /right margin/	23 мм
Хуудасны дээд талаас авах зай /top margin/	23 мм
Хуудасны доод талаас авах зай /bottom margin/	23 мм
Зурган текст	10 pt, italic
Татаж оруулах (Scanner ашиглаж оруулсан) бүдүүвч зураг болон фото зургийг буулгаж мөр голлуулан байрлуулна.	300 dpi нягтралтай *.TIF, *JPEG, *.BMP, *.GIF өргөтгөлтэй
Математик томъёо	Equation програм ашиглан 10pt өндөртэйгээр мөр голлон бичнэ. Томъёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага хаалтанд бичнэ.
Ашигласан материалын жагсаалт	Дугаарыг бүтээлийн өмнө дөрвөлжин хаалтад [...] бичнэ.

4.2. Бүтээл нь хэл, найруулгын алдаагүй, хэвшмэл бус нэрийг товчлоогүй, эх сурвалжийг зайлшгүй дурдсан, эшлэлийг хуудасны доод хэсэгт дурдсан байна.

4.3. Бүтээлийг B5 хэмжээний цахим хэлбэрээр ирүүлнэ.

## **5. Цуврал бүтээл гаргах хугацаа**

5.1. Тухайн сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн “Манай эрдэмтэд” цуврал бүтээлийг гаргах хүсэлтийг ШУТИС-ийн хэвлэлийн Редакцийн зөвлөлд ирүүлнэ. Нэг хичээлийн жилд шийдвэрлэх 3-аас илүүгүй бүтээл гарна.

5.2. Бүрэлдэхүүн сургуулиуд цуврал бүтээл гаргах талаар саналаа хичээлийн жилийн эхэнд ШУТИС-ийн хэвлэлийн Редакцийн зөвлөлд ирүүлнэ.

## **6. Бүтээлийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх**

6.1. Бүтээлээс 20 ширхэгийг ШУТИС-ийн захиргаанд хүлээлгэн өгөх ба үүнээс 10 ширхэгийг зохиогчид эргүүлэн олгож, үүнээс сургуулийн сурталчилгааны самбарт 1 ширхэгийг байрлуулж, Ректор, Эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн проректор, Эрдэм шинжилгээний албанд тус бүр 1 ширхэгийг хуваарилна. Үлдсэн хувийг багш, судлаачид, хамтын ажиллагаатай байгууллагын холбогдох хүмүүст бэлэглэнэ.

## **7. Санхүүжилт**

7.1. Цуврал бүтээл тус бүрийг 100 ширхэг хэвлэж, 20 хувийн зардлыг ШУТИС-ийн төвлөрсөн зардлын сангаас, 50 хувийг бүрэлдэхүүн сургуулиас гаргаж, үлдсэн хувийг зохиогч өөрөө хариуцна.